

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ДАРГА В.В.ПУТИН МОНГОЛ УЛСАД АЖЛЫН АЙЛЧЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ ХЭВЛЭЛИЙН ХАМТАРСАН МЭДЭЭ

Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путин Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын урилгаар 2009 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсад ажлын айлчлал хийв.

Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путин Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяртай хэлэлцээ хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Улсын Их Хурлын Дарга Д.Дэмбэрэл нарт бараалхав.

Харилцан ойлголцох, бие биеийнхээ эрх ашгийг уламжлан хүндэтгэх байдалд болсон хэлэлцээ, уулзалтуудын явцад Монгол, Оросын харилцааны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, бүс нутгийн болон олон улсын зарим сэдвээр санал солилцлоо.

Засгийн газрын Тэргүүн нар дээд, өндөр хэмжээнд тогтмол явагдаж байгаа яриа хэлэлцээ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын стратегийн түншлэлийг давшингүй хөгжүүлэх, хоёр улсын ард түмнүүдийн хоорондын сайн хөршийн уламжлалт найрамдлыг бүх талаар бэхжүүлэн гүнзгийрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны нэгдүгээр сарын 20-ны Гэрээ, 2000 оны арваннэгдүгээр сарын 14-ний Улаанбаатарын Тунхаглал болон 2006 оны арванхоёрдугаар сарын 8-ны Москвагийн Тунхаглал зэрэг үндсэн баримт бичгүүдийн заалтуудыг цаашид хэрэгжүүлэх чиглэлээр авч байгаа арга хэмжээ болон хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг цаашид өргөжүүлэн боловсронгуй болгох талаар хэлэлцлээ.

Худалдаа-эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны асуудалд онцгой анхаарал тавилаа. Энэ хүрээнд хоёр улсын засгийн газрын тэргүүн нар Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийг бүрэн дүүрэн, цаг тухайд нь хэрэгжүүлэхийн тулд хоёр талын хамтын ажиллагааны гол механизм- худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны ЗГХК, түүний ажлын хэсгүүдийг үр нөлөөтэй, тогтмол ажиллуулахын чухлыг онцлон тэмдэглэв.

Орос Улстай хийж байгаа Монголын худалдааны алдагдлыг багасгах, хоёр талын худалдааны эргэлтийг өргөжүүлэх зорилгоор

зарим нэрийн барааг хөнгөлөлттэй нөхцлөөр харилцан нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээр байгуулах санаачилгыг Монголын тал дэвшүүлэв. Оросын тал хоёр талын худалдааг либералчилах асуудлыг шийдвэрлэх явдлыг Засгийн газар хоорондын комиссын холбогдох Ажлын хэсгийн хүрээнд үргэлжлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

“Ростехнологи” улсын корпораци Монгол, Оросын хамтарсан үйлдвэрийн газрууд-хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд болох “Эрдэнэт үйлдвэр” болон “Монголросцветмет”-д оролцох болон “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн оросын хувийг “Оросын төмөр зам” НХН-ийн итгэмжилсэн удирдлагад шилжүүлэх үйл явц амжилттай дууссаныг сэтгэл ханамжтай тэмдэглэв.

Хөдөө аж ахуйн салбарт, түүний дотор Монгол Улсын Засгийн газрын “Атар-III” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгааг Талууд өндөр үнэлэв. Монголын тал Орос Улсад экспортлох мах, махан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Оросын тал Монгол Улсад үр тариа нийлүүлэхээ нэмэгдүүлэх, хоёр оронд үйлчилж байгаа мал эмнэлэг, эрүүл ахуйн хяналтын хэм хэмжээг харгалзан Монголын талын саналыг анхааралтай авч үзэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

Талууд Монгол, Оросын худалдааны үндсэн хэсэг ноогддог хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тааламжтай нөхцлийг бий болгох үүднээс хамтран ажиллахаар тохиролцлоо. Үүнтэй уялдуулан засгийн газрын тэргүүн нар Монгол, Оросын хил нэвтрэх боомтуудын үйл ажиллагааны асуудлыг Хилийн боомт болон Монгол, Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн Хэлэлцээрийн дагуу судалж үзэх үүргийг Засгийн газар хоорондын комисст өглөө. Тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нь газар тариалангийн цогцолбор байгуулах салбарт түншлэх тухай тохиролцоонуудыг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Талууд атомын эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах засгийн газар хоорондын хоёр талын багц баримт бичгүүд, тухайлбал ураны хүдрийн хайгуул, олборлолт болон боловсруулах хамтарсан үйлдвэрийг байгуулах тухай хэлэлцээрийг бэлтгэх ажлыг түргэвчлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

Монголын тал Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээн дэх эдийн засгийн, түүний дотор эрчим хүчний төслүүдэд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Чингэхдээ талууд

Монгол, Оросын хоёр талын эрчим хүчний яриа хэлэлцээг цаашид өрнүүлэхийн төлөө байна.

Хоёр улсын засгийн газрын тэргүүн нар “Таван Толгой” зэрэг Монголын ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглахад шаардлагатай дэд бүтцийг байгуулах талаар санал солилцож, төмөр замын хамтарсан компани байгуулах асуудлыг хэлэлцлээ.

Талууд хоёр талын цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгааг тэмдэглэв. Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх болон боловсон хүчнийг бэлтгэх салбарт тусламж үзүүлж байгаад Монголын тал Оросын Холбооны Улсад талархал илэрхийлэв.

Талууд Халх голын байлдааны хамтын ялалтын 70 жил, Монгол, Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг байгуулагдсаны 60 жил, Монголд атар газар эзэмшиж эхэлсний 50 жилийн ойг энэ онд тэмдэглэх хүрээнд үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээний талаар харилцан мэдээллээ.

Хоёр улсын засгийн газрын тэргүүн нар хоёр орны шинжлэх ухаан, техник, соёл, боловсрол, спортын салбарын солилцоог цаашид өргөжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэв. Үүнтэй уялдуулан Оросын соёлын өдрүүдийг 2009 онд Монгол Улсад, Монголын соёлын өдрүүдийг 2010 онд Оросын Холбооны Улсад зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулахад талууд ихээхэн ач холбогдол өглөө. Хэлэлцээнд оролцогчид ОХУ-ын их дээд сургуулиудын салбаруудыг Монгол Улсад цаашид хөгжүүлэх төлөвлөгөөг дэмжив. Хилийн чанадад орос хэл сурах явдлыг дэмжих холбооны хөтөлбөрийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа улсуудын тоонд Монголыг хамруулсан тухай монгол түншүүдэд мэдээлэв.

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Оросын Холбооны Улсын хөдөө аж ахуйн сайд нарын хамтарсан Мэдэгдэл, Монгол Улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, ОХУ-ын Тээврийн яам хоорондын харилцан ойлголцох тухай Санамж бичиг, Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компани, “Эрдэнэс МГЛ” хязгаарлагдмал хариуцлагатай компани болон “Оросын төмөр замууд” нээлттэй хувьцаат компанийн хоорондын Хэлэлцээр, Мэргэжилтэн бэлтгэх талаар Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Цөмийн энергийн газар, Оросын Холбооны Улсын Атомын энергийн улсын “Росатом” корпораци хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг, МИАТ ХК болон Аэрофлот компаниуд хоорондын Код хамтран ашиглах Хэлэлцээрт гарын үсэг зурахад С.Баяр, В.В.Путин нар байлцлаа.

Талууд харилцан сонирхсон бүс нутгийн болон олон улсын тулгамдсан асуудлууд тухайлбал, бүх нийтийн аюулгүй байдал, НҮБ-ын үүрэг ролийг бэхжүүлэх, дэлхийн санхүү-эдийн засгийн хямралын үр дагаварыг гэтлэн давах асуудлуудыг хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын уламжлалт найрсаг харилцаа, олон талт хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлж Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путинг “Эрдэнийн Очир” одонгоор шагнасныг гардуулав.

Хоёр орны засгийн газрын тэргүүн нар “Россельхозбанк” НХН-ийн шугамаар хэрэгжүүлэх зээлийн хүрээнд Монгол Улсад нийлүүлсэн Оросын хөдөө аж ахуйн техникийн эхний хэсгийг хүлээж авах ажиллагаанд оролцож, Оросын нэрт аялагч Ф.Конюховын олон улсын багийн “Торгоны их зам”-аар хийх аялалыг эхлүүллээ.

Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путин домогт жанжин Г.К.Жуковын хөшөөнд цэцэг өргөж, Оросын үнэн алдартны шашны Улаанбаатар дахь Свято-Троицын сүмд зочлов.

Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга В.В.Путин халуун дотноор хүлээн авсанд талархал илэрхийлж, Монгол Улсын Ерөнхий сайдыг тааламжтай цагтаа Орос Улсад айлчлахыг урив. С.Баяр урилгыг талархан хүлээж авав.

Улаанбаатар хот, 2009 оны 5 дугаар сарын 13